

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ОГНОО: 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 14:00 цаг

ХУРАЛ ХУРАЛДСАН ГАЗАР: Байгууллагын вебсайтаар дамжуулан цахим хэлбэрээр.

ХУРЛЫН ДАРГА: Инвескор ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал Д. Баясгалан

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

- 2022 оны хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
- Инвескор ББСБ ХК-ийн дүрэм /Шинэчлэсэн найруулга/-ийн төсөл;
- Компанийн хувьцаа хуваах тухай төсөл;
- Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн танилцуулга;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны төсвийн санал.

А. Энэрэл: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргье. Инвескор ББСБ хувьцаат компанид итгэл үзүүлж бидний санхүүгийн үйл ажиллагаа болон манай баг хамт олонд итгэл найдвар үзүүлэн манай компанийн хувьцаа эзэмшигч болсон та бүхэнд маш их баярлалаа.

Эхлээд ирцийн мэдээлэл танилцуулахаар Тооллогын комиссын дарга Х. Галхүүг урьж байна.

Тооллогын комиссын дарга Х. Галхүү: Сайн байна уу, та бүхэнд хурлын ирцийг мэдээллэе. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 14:00 мин хүртэл хийлээ. Тооллогын комиссын тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон хурлын хүчин төгөлдөр тооцох тухай. Инвескор ББСБ ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 07 сарын 20-ны өдрийн 24 тоот тогтоол болон КтХ-ийн 67.3.1, 69-р зүйлийг тус тус үндэслэн тогтоох нь: Инвескор ББСБ ХК-ийн 2022.09.07-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийн бүртгэлийн нийт 71,419,448ш хувьцааг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож байгаа нь компанийн нийт саналын эрх бүхийн 75,744,281ш хувьцааны 94.3%-ийг эзэлж байгаа буюу компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөр тооцох ирц бүрдсэн болохыг тогтоож хуралд оролцогч болон хурлын даргад мэдээллэж байна.

Хурлын дарга Д. Баясгалан: Ирцийн мэдээллийг танилцуулсанаар ирц ийнхүү тасалбар болж байгааг мэдэгдэе. Хурлын дарааллын дагуу Хурлын дэгийг батлая. Хурлын дэгээр хэлэлцэх асуудлуудын танилцуулга эхлээд явагдана. Үүний дараа хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой асуулт, хариулт явагдаж, дараа нь нэгдсэн байдлаар санал хураалтыг хураах гэсэн дэгтэй явна. Бүгдээрээ хурлын дэгээ баталцгаая. Одоо Компанийн охин компани болох Инвескор Киргизийн мэндчилгээг хүлээн авна уу.

Хурлын дарга Компанийн үйл ажиллагааг талаарх мэдээллийг товч өгөв.

Дэд захирал Н. Арсланбаатар: 2022 онд Компани чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001 болон Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001 олон улсын стандартуудыг амжилттай нэвтрүүлсэн 2021 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 25 төгрөг буюу нийт 1.8 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд тараасан, “Рио Тинто Монгол” ХХК-тай хамтран хэрэгжүүлсэн Монгол улсын эдийн засгийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бизнес эрхлэгчдэд 1 сая ам.доллартай тэнцэх хэмжээний хөнгөлөлттэй зээл олгосон, Нидерланд улсын Краудфандинг платформ болох “Hands-on B.V.” компаниас 2.5 сая ам.доллар татах хэлэлцээр хийсэн, “Покет КГ” ХХК нь Киргиз улсын төв банкнаас төлбөрийн системийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлөө авсан, мөн Төв Азийн зах зээлд тэлэлт хийх стратегийн хүрээнд Казакстан улсад охин компани байгуулсан.

Компани 2022 оны эхний хагас жилийн байдлаар 17 салбартай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Улаанбаатар хотод 16, Эрдэнэт хотод 1 салбар тус тус байрлаж, 1 салбарын үйл ажиллагаа бүрэн цахимаар явагдаж байна. Зээлийн ажилтнууд компанийн болон хэрэглэгчдийн цагийг хэмнэхийн тулд үйл ажиллагаанд таблет ашиглах үйл ажиллагааг эхлүүлж байна. Компани олон улсын зах зээлд тэлэх стратегийн хүрээнд Киргизстан улсад 2 охин компани (“Инвескор Си Эй” МФК, “Покет КГ” ХХК), Казакстан улсад 1 охин компани (“Инвескор КЗ” ХХК) тус тус байгуулаад байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар, охин компани болох “Инвескор Си Эй” МФК нь Киргизстан улсад 3 салбартай үйл ажиллагаагаа явуулж байна.

Эрсдэлийн удирдлагын засаглал:

- “ИнвескорББСБ”ХК нь 2022 оны эхний хагаст Хамгаалалтын 3 бүсийн зарчимд тулгуурлан өөрийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хязгаарын хүрээнд эрсдэлийг үр дүнтэй удирдаж ажилласан.
- Түүнчлэн, зохицуулагч байгууллагын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллав.
- Эрсдэлийн удирдлагын засаглалын хороодын үйл ажиллагаа, чиг үүргийг нарийвчлан тодорхойлж, шинэчлэн зохион байгуулав.

Зээлийн эрсдэлийн удирдлага

- Зээлийн эрсдэлийг удирдах, зээлийн үйл ажиллагааг зохицуулах бодлого, журмуудыг жил тутмын үнэлгээний хүрээнд сайжруулан боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Зээлийн үйл ажиллагаанд тавигдах хяналт, мониторингийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор Зээлийн мониторинг хариуцсан нэгжийн үйл ажиллагааг тодорхойлж, Эрсдэлийн удирдлагын нэгжийн харьяанд нэгтгэв.

СУХЗГ-ын захирал С. Тулга: 2022 оны эхний хагас жилийн үр дүн

- ✓ Нийт зээлийн багц өмнөх оны мөн үетэй харьцуулахад 108%-р өсч, 253 тэрбум төгрөгт хүрсэн.
 - ✓ Зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 120%-иар өсч, 116,101-д хүрсэн.
 - ✓ Нэг зээлдэгчид ногдох зээлийн дундаж хэмжээ 2.2 сая төгрөг
 - ✓ Зээлийн багцын хэмжээгээр дотоодын зах зээлд эзлэх хувь 10.1%
 - ✓ Зээлийн олголт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 142%-р, эргэн төлөлт 130%-р тус тус нэмэгдсэн байна.
 - ✓ 2022 оны сүүлийн хагас жилд бизнесийн зээлийн олголтыг илүү нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.
 - ✓ Бизнесийн харилцагч нарт бид зөвхөн санхүүжилт олгохоос гадна сургалт, зөвлөх үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж, харилцагчаа дэмжиж ажилласаар ирсэн.
 - ✓ Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн эзлэх хувь санхүүгийн секторын хэмжээнд бага түвшинд байна.
 - ✓ Хугацаа хэтрэлт: Банк салбар 3.9% , ББСБ салбар 3.9%
 - ✓ Чанаргүй зээл: Банк салбар 4.7% , ББСБ салбар 9.0%
- Нийт хөрөнгө: 289 тэрбум төгрөг Эздийн өмч: 89 тэрбум төгрөг
- Жилийн өмнөхтэй харьцуулахад: Нийт хөрөнгө 85%-иар өссөн Эздийн өмч 51%-иар өссөн
- Хүү, шимтгэлийн орлого: 41 тэрбум төгрөг Цэвэр ашиг: 15 тэрбум төгрөг
- Жилийн өмнөхтэй харьцуулахад:
- Хүү, шимтгэлийн орлого 115%-иар өссөн Цэвэр ашиг 103%-иар өссөн

Хэлэлцүүлэх асуудал 1:

СУХЗГ-ын захирал С. Тулга: Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Нэмж хувьцаа гаргаснаар:

Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийтэд санал болгосон эзэмшлийн хувь	5.30%
Гаргасан хувьцааны тоо	4,016,363 ширхэг*
Санал болгосон нэгж хувьцааны үнэ	4,155 төгрөг (60 арилжааны өдрийн хугацаагаар жигнэсэн дундаж ханшийг 3%-р хямдруулан тооцоолсон)
Нийт дүн	16.7 тэрбум төгрөг
Стратегийн хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалт	11.9 тэрбум (73%)
Стратегийн хөрөнгө оруулагчдын түгжих хугацаа	9 сар
Олон нийтийн хөрөнгө оруулсан хувь	4.5 тэрбум (27%)
Хувьцааг арилжаалсан арга	Тогтоосон үнийн арга
Захиалга авсан хугацаа	2022/06/27-07/01
Зарцуулалт	70% - Дотоодын зах зээлд 30% - Гадаадын зах зээлийн тэлэлтэд

Компанийн дүрэмд дараах өөрчлөлт орно:

Одоогийн заалт	Өөрчлөлтийн дараа
5.3. Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо нь нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 71,727,918 (далан нэгэн сая долоон зуун хорин долоон мянга есөн зуун арван найман) ширхэг байна.	5.3. Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо нь нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 75,744,281 (далан таван сая долоон зуун дөчин дөрвөн мянга хоёр зуун наян нэгэн) ширхэг байна.

Хэлэлцүүлэх асуудал 2: Хувьцаа хуваах тухай

Компанийн тухай хуулийн 51 болон 63-р зүйлийн дагуу компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурал нь тус асуудлаарх саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар энэхүү төслийг хэрэгжүүлэх бүрэн үндэслэл болно.

Монгол Улсын Компанийн тухай хууль

51.3.Компани нь нэг хувьцааг тухайн төрлийн шинэ хоёр буюу түүнээс дээш тооны хувьцаанд хөрвүүлэх замаар өөрийн гаргасан хувьцаагаа хувааж болно.

51.4.Компани нь хувьцааг хуваах болон нэгтгэсний үр дүнд бий болсон хувьцааны бутархай үлдэгдлийг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-өөс тогтоосон үнээр эргүүлэн худалдаж авч болно.

51.5.Компанийн хувьцааг нэгтгэх буюу хуваах тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

51.6.Компанийн хувьцааг нэгтгэх буюу хуваахад компанийн зарласан тухайн төрлийн хувьцааны тоонд орсон өөрчлөлтийг компанийн дүрэмд тусгаж, энэ тухай бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

Компанид үүсэх давуу тал:

- ✓ Хувьцааны арилжааны идэвх болон хөрвөх чадварыг нэмэгдүүлнэ
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн тоог нэмэгдүүлнэ
- ✓ Хувьцааны төвлөрлийг бууруулна
- ✓ Хувьцааны эрэлтийг нэмэгдүүлж, ханш болон зах зээлийн үнэлгээ өсөхөд эерэг нөлөө үзүүлнэ
- ✓ Хувьцаа эзэмшигчдэд үүсэх давуу тал:
- ✓ Хувьцааны арилжааны идэвх болон хөрвөх чадварыг нэмэгдүүлнэ
- ✓ Жижиг хувьцаа эзэмшигчдийн үүрэг оролцоо илүү идэвхжинэ
- ✓ Хувьцааны эрэлтийг нэмэгдүүлж, ханш болон зах зээлийн үнэлгээ өсөхөд эерэг нөлөө үзүүлнэ

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас нэг хувьцааг 100 хуваах шийдвэр гаргасан тохиолдолд Компанийн дүрэмд доорх байдлаар өөрчлөлт орох болно:

✓ Одоогийн заалт	Өөрчлөлтийн дараа
5.2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоо нь нэг бүр нь 2.27 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 82,000,000 (наян хоёр сая) ширхэг байна.	5.2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоо нь нэг бүр нь 2.27 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 8,200,000,000 (найман тэрбум хоёр зуун сая) ширхэг байна.
5.3. Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо нь нэг бүр нь 2.27 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 75,744,281 (далан таван сая долоон зуун дөчин дөрвөн ширхэг хоёр зуун наян нэгэн) ширхэг байна.	5.3. Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо нь нэг бүр нь 2.27 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 7,574,428,100 (долоон тэрбум таван зуун далан дөрвөн сая дөрвөн зуун хорин найман мянга нэг зуун) ширхэг байна.

Хэлэлцүүлэх асуудал 3: ТУЗ-ийн нийт гишүүдийг сонгох тухай

А. Энэрэл: Инвескор ББСБ ХК-ийн ТУЗ-д хараат болон хараат бус гишүүдийг тодруулаад батлана. ТУЗ-ийн есөн гишүүний бүрэн эрхийн хугацаа 2022 онд дууссантай холбоотойгоор ТУЗ-ийн

дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн нийт гишүүдийн сонгон шалгаруулалтын зарыг 06 дугаар сард явуулсан. Тус сонгон шалгаруулалтад 3 хүн материалаа өгснөөс 1 хүн компанийн засаглалын гэрчилгээ аваагүй, 2 дахь хүн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтад материалаа өгсөн боловч сонирхлын зөрчилтэй байсан нь аль аль нь ТУЗ-ийн гишүүдэд тавьсан шаардлагад нийцээгүй байна. Ингээд та бүгдэд өнөөдөр ТУЗ-ийн нэр дэвшигчдийн танилцуулгыг танилцуулая.

1. Б. Анхболд: Одоогийн байдлаар Инвескор ББСБ ХК-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Өмнө нь Шунхлай группын Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан, Японд менежментийн чиглэлээр ажиллаж байсан. Японы Рицумэйкан Ази-Номхон Далайн Их Сургуульд Бизнесийн удирдлагын чиглэлээр Бакалавр, болон Магистрын зэрэг хамгаалж суралцсан. Санхүүгийн захирал, компанийн менежментийн талаар зөвлөгөө өгөх, консалтингийн чиглэлээр ажилласан гишүүн байгаа юм.
2. Д. Баясгалан: Инвескор ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирлын албыг хашиж байна. Ажлын туршлагын хувьд Монголбанкнаас гараагаа эхэлсэн. Төслийн менежерээр, мөн ХХБ-д Санхүүгийн газрын ахлах мэргэжилтнээр ажиллаж байсан, мөн МУИС-ийн Эдийн засгийн ухааны Бакалавраар төгссөн гишүүн байна.
3. Р. Пүрэв: Инвескор ББСБ ХК-ийн Санхүү эрхэлсэн дэд захирлын албыг хашиж байсан. Банк санхүүгийн байгууллагуудад 15 жил, 5 жил аудиторoor ажилласан туршлагатай. Компанийн дотоод хяналт, процесс менежмент, дата шинжилгээ, олон улсын нягтлан бодох бүртгэл чиглэлүүдээр мэргэшсэн.
4. Хирохито Намики: Инвескор ББСБ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн. Туршлагын хувьд ББСБ-д олон жил ажилласан. АНУ-ын Рочестэр их сургуульд Бизнес удирдлагын Магистр, Японы Кэйо их сургуульд Бизнес удирдлагын Бакалавр эзэмшээд Мицүбиши Юу Эф Жэй итгэлцлийн байгууллагад Ахлах шинжээчээр ажиллаж, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Хөрөнгө оруулагчаар ажиллаж байсан.
5. Г. Уянгахишиг: Инвескор ҮЦК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг. Боловсролын хувьд Бонн хотын Хууль зүйн их сургуулийн Хууль зүйн Магистр, МУИС-ийн Хууль зүйн сургуульд Хууль зүйн Бакалавр, Эрх зүйч эзэмшсэний дараагаар Цэц хуулийн фирмд Өмгөөлөгч, Партнер, Си Энд Жи Партнерс хуулийн фирмийн Үүсгэн байгуулагч партнер, Шунхлай Групп ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан Захирал, Голомт Банкинд Хуулийн хэлтсийн Захиралаар тус тус ажиллаж байсан.
6. Т. Тэлмэн: Амар Даатгал ХХК-ийн Бизнес хөгжлийн газрын Захирал. Боловсролын хувьд Миссури мужийн их сургуульд Бизнес удирдлагын Магистр, СЭЗДС-д Санхүүч, Банкны эдийн засагчаар Бакалаврын зэрэг эзэмшсэн. Ажлын туршлагын хувьд Монгол алт компанид Хөрөнгө оруулалтын газрын Захирал, Микрокредит ББСБ-ын Гүйцэтгэх Захирал, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамын сайдын зөвлөх, Монгол Амьдрал ХХК-ийн Захирлаар тус тус ажиллаж байсан туршлагатай.

Хараат бус гишүүдэд нэр дэвшиж байгаа хүмүүсийг танилцуулая.

1. Д. Энхбат: Хархорум дижитал ХХК-ийн Ерөнхий захирлаар ажиллаж байна. Монголын цахим шилжилтийг эхлүүлсэн гэж хэлж болно. Боловсролын хувьд Уралын техникийн их сургуулийн Системийн инженер, ШУТУИС /МИСИС/-д Техникийн ШУ-ны Докторын зэргийг хамгаалж, Үндэсний хөгжлийн яамд Дэд сайд хийж байсан, Датаком ХХК-ийн Ерөнхий захирал, УИХ-ын гишүүн, Нээлттэй мэдлэг боловсролын хүрээлэнд УЗ-ийн даргаар тус тус ажиллаж байсан.
2. Ч. Өнөржаргал: СЭДИС-ийн Ахлах багш. СЭЗДС-д Бизнесийн удирдлагын Бакалавр, Нягтлан бодогч, Эдийн засагч, МУИС-ийн Эдийн засгийн сургуульд Бизнес удирдлагын Магистрийн зэргийг авч ХҮДС-д Багш, Футура Фэйшн ХХК-д Санхүү, НББ-ын зөвлөх, Саксон Монголиа ХХК-д Гэрээт нягтлан бодогч, БДО Такс ТМЗ ХХК-д Татварын Ахлах зөвлөхөөр тус тус ажиллаж байсан.
3. Ч. Хашчулуун миний бие: Москвагийн их сургуульд Эдийн засгийн ухааны Бакалавр, Япон улсын Ёкохама болон Кэйо их сургуульд Эдийн засгийн ухааны Магистр, Докторын зэрэг хамгаалж Монголбанкинд Мөнгөний бодлогын зөвлөл, Захирлуудын зөвлөлөөр 2006 оноос ажиллаад Хөгжлийн банкны ТУЗ-ийн Даргаар ажиллаж байсан туршлагатай. Одоогийн

байдлаар МУИС-ийн Эдийн засгийн тэнхимд Профессороор ажиллаж байгаа, мөн Инвекор ББСБ ХК-д ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр ажиллаж байна.

Ингээд нэр дэвшигчдийн танилцуулгыг хийлээ. Нийт 9 гишүүний 8 гишүүн нь улиран сонгогдохоор нэр дэвшиж, нэг гишүүн шинээр нэр дэвшиж байна.

Дараагийн асуудал бол ТУЗ-ийн төсвийн төсөл. ТУЗ-ийн төсөв дээр хараат бус 4 гишүүнд олгох цалин жилийн 48 сая, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин жилийн 2.4 сая, ТУЗ-ийн хурлын зардал 500 мянга, томилолтын зардал 10 сая төгрөг, бусад 2.4 сая, нийт 63.3 сая төгрөгийн төсвийн төслийг танилцуулж байна. Энэ төсөв 2023 оны 04-р сарыг дуустал хугацаагаар боловсруулсан.

А. Энэрэл: Асуулт хариултын хэсэг өндөрлөж байна. Үүний дараа Тооллогын комиссын дарга Х. Галхүү саналын хуудсыг бөглөх заавар, зөвлөмжийн талаарх танилцуулга видеог хүлээн авна уу.

Санал хураалтын цаг эхлэв.

А. Энэрэл: Хурлын үйл ажиллагаандаа орьё. Бүгдээрээ саналаа өгсөн байх гэж найдаж байна. Санал хураалтын үр дүнгийн талаар Тооллогын комиссын дарга Х. Галхүү мэдээллэнэ.

Тооллогын комиссын дарга Х. Галхүү: Инвекор ББСБ ХК-ийн тооллогын комиссийн шийдвэр, санал хураалтын үр дүнгийн талаар танилцуулая. Инвекор ББСБ ХК-ийн 2022 оны 09 сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцож санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг тоолж дүн нэгтгэсний үндсэн дээр шийдвэрлэх нь:

Нэгт. Дүрмийн шинэчлэсэн найруулга батлах асуудлаар хурлын ирц 94.3%, зөвшөөрсөн 71,077,739ш хувьцаа буюу нийт хувьцааны 99.5%-р зөвшөөрсөн байна.

Хоёрт. Компанийн хувьцаа хуваах тухай асуудлаар хурлын ирц 94.3%, зөвшөөрсөн 99.5%, татгалзсан 0%, түтгэлзсэн 0% саналыг тус тус өгсөн.

Гуравт. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлаар хурлын ирц 94.3%, хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн нийт кумулятив саналын тоогоор:

- Б. Анхболд – 99.7%
- Д. Баясгалан – 99.6%
- Г. Уянгахишиг – 99.5%
- Т. Тэлмэн – 99.4%
- Намики хирохито – 99.4%
- Р. Пүрэв – 99.4%
- Д. Энхбат – 99.5%
- Ч. Хашчулуун – 99.5%
- Ч. Өнөржаргал – 99.4% санал тус тус авсан байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураасан. Дээрх санал хураалтын дүн болон дүнгийн талаарх шийдвэрийг хурал оролцогч хувьцаа эзэмшигчдэд ийнхүү мэдээлсүгэй гэсэн байна.

А. Энэрэл: Тооллогын комиссын дарга Батчимэг захиралдаа баярлалаа. Саяны санал хураалтын үр дүнтэй холбоотойгоор гарах 3 тогтоол бэлэн болсон байна.

Нэгт. Дүрмийн шинэчлэсэн найруулгыг батлах тухай

“Инвекор ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг болон Тооллогын комиссын [ДУГААР] дугаар шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг Хавсралтаар баталсугай;
2. Компанийн Дүрмийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн хэлтэст зохих бүртгэлийг хийлгүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д даалгасугай.

2022 оны 09 сарын 07-ны өдөр

Хоёрт. Компанийн хувьцаа хуваах тухай.

Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.6 дахь заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.6 дахь заалт, 2022 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 82,000,000 ширхэг зарласан энгийн хувьцааны нэгж хувьцаа бүрийг 100 хувааж нэг бүр нь 2.27 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 8,200,000,000 ширхэг зарласан энгийн хувьцаа болгон хуваасугай.
2. Компанийн нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 75,744,281 ширхэг гаргасан энгийн хувьцааны нэгж хувьцаа бүрийг 100 хувааж нэг бүр нь 2.27 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 7,574,428,100 ширхэг гаргасан энгийн хувьцаа болгон хуваасугай.
3. Компани нь нэг бүр нь 2.27 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 625,571,900 ширхэг зарласан боловч гаргаагүй хувьцаатай болохыг дурдсугай.
4. Компанийн хувьцааг хуваах зорилго, үндэслэл, хувьцаа хуваах ажлыг гүйцэтгэх журмыг тусгасан “Хувьцаа хуваах төсөл”-ийг шийдвэрийн Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
5. Компанийн хувьцаа хуваасантай холбоотой өөрчлөлтийг тусгасан Компанийн дүрмийн төслийг Хоёрдугаар хавсралтаар баталсугай.
6. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлж, Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, Санхүүгийн зохицуулах хороонд үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлт гаргах, бүртгүүлэх, зөвшөөрөл авах, зөвшөөрөл авсны үндсэн дээр Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох өөрчлөлтийг бүртгүүлэх болон зохих журмын дагуу мэдээллийг нийтийн хүртээл болгох зэрэг шаардлагатай арга хэмжээ авахыг Гүйцэтгэх захирал (Д.Баясгалан)-д даалгасугай.

2022 оны 09 сарын 07-ны өдөр

Гуравт. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай.

“Инвескор ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах хэсэг болон Тооллогын комиссын [ДУГААР] дугаар шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгосугай;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 (гурван) жилийн хугацаатайгаар сонгосугай;

Саяны нэр дэвшсэн гишүүд бүгд батлагдсан байгаа.

3. Компанийн тухай хууль, Компанийн Дүрэм, Засаглалын Кодекс болон бусад холбогдох хууль тогтоомжийн актуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай;
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шинэ бүрэлдэхүүний мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, зохих зөвшөөрөл авах ажлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /А. Энэрэл/-д үүрэг болгосугай.

2022 оны 09 сарын 07-ны өдөр

Ингээд эдгээр тогтоолууд батлагдсан байна.

Хурлын дарга Д. Баясгалан: Хувьцаа эзэмшигчдийн хувьд компанийн үйл ажиллагаандаа оролцож буй нэг хэлбэр бол хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхитэй оролцож саналаа өгөх байдаг. Энэ хуралдаа идэвхитэй ирж саналаа өгсөн та бүхэнд маш их баярлалаа. Ингээд хурлын үйл ажиллагаа хааж байгааг мэдэгдэж байна.

Хурал 16:40 минутанд хаав.

ХУРЛЫН ДАРГА



Д. БАЯСГАЛАН

“ИНВЕСКОР ББСБ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурал
хуралдсан газар: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
11-р хороо, Зайсангийн Тойруу-1, 40 хаяг

Тооллогын комиссын дарга: Х.Галхүү
Тооллогын комиссын гишүүд: Б.Одхүү
И.Тамир
Ө.Энхзаяа

Ирц бүртгэх эхэлсэн цаг, минут: 13 цаг 30 минут
Ирц бүртгэл хаасан цаг, минут: 14 цаг 00 минут

Тэмдэглэл

Тооллогын комиссын дарга: *Хувьцаа эзэмшигчдийн урьдчилж өгсөн саналын хуудаснуудыг бүртгэсэн мэдээллийг гаргаж өгнө үү?* гэснээр Тооллогын комиссын гишүүд Үнэт цаасны компаниудаас Тооллогын комисст 2022 оны 09-р сарын 06-ны өдрийн 18 цаг 00 минутаас өмнө хүлээлгэн өгсөн хувьцаа эзэмшигчдийн урьдчилан өгсөн саналын бүртгэлийг Тооллогын комиссын даргад хүлээлгэн өгөв.

Тооллогын комиссын гишүүдийн урьдчилж өгсөн саналын бүртгэлийг Тооллогын комиссын дарга тулган баталгаажуулж хурлын ирцийн бүртгэлийн мэдээлэлд оруулав.

Тооллогын комиссын дарга: *Хуралд урьдчилж санал өгсөн хувьцаа эзэмшигчид болон цахим хэлбэрээр оролцсон хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийн мэдээллийг нэгтгэсэн байдлаар гаргаж өгнө үү?* гэснээр Тооллогын комиссын гишүүд хуралд цахим хэлбэрээр оролцож буй хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл болон урьдчилж санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн саналтай нэгтгэж Тооллогын комиссын даргад хүлээлгэн өгөв.

Тооллогын комиссын дарга: *Хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг тулган баталгаажуулсан нь дараах байдалтай байна. Үүнд:*

1. *Урьдчилж санал өгсөн хувьцаа эзэмшигчид:*
 - *Хувьцаа эзэмшигчийн тоо - 100*
 - *Эзэмшиж буй саналын эрх бүхий хувьцааны тоо – 71,195,088*
 - *Компанийн нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь – 93.99%*
2. *Цахим хэлбэрээр хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:*
 - *Хувьцаа эзэмшигчийн тоо - 13*
 - *Эзэмшиж буй саналын эрх бүхий хувьцааны тоо – 224,360*
 - *Компанийн нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь – 0.30%*

“Инвескор ББСБ” ХК-ийн 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийн бүртгэлийн дагуу нийт 71,419,448 (далан нэгэн сая дөрвөн зуун арван есөн мянга дөрвөн зуун дөчин найм) ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож байгаа нь Компанийн нийт саналын эрх бүхий 75,744,281 (далан таван сая долоон зуун дөчин дөрвөн мянга хоёр зуун наян нэг) ширхэг энгийн хувьцааны 94.29 хувьтай тэнцэж байгаа тул Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцох ирц бүрдсэн болохыг тогтоох уу?

Тооллогын комиссын гишүүн Б.Одхүү: Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцох ирц бүрдсэнийг тогтоохыг дэмжиж байна.


Тооллогын комиссын гишүүн И.Тамир: Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцох ирц бүрдсэнийг тогтоохыг дэмжиж байна.


Тооллогын комиссын дарга: Ирцтэй холбоотой нэмэлт тайлбар, тэмдэглэл бий юу?

Тооллогын комиссын гишүүд: Байхгүй гэснээр

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцох ирц бүрдсэн болохыг тогтоож, хуралд оролцогчид болон хурлын даргад ирцийг танилцуулахаар тогтов.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ТЭМДЭГЛЭЛИЙГ БАТАЛГААЖУУЛСАН:


Х.ГАЛХҮҮ /Тооллогын комиссын дарга/


Б.ОДХҮҮ /Тооллогын комиссын гишүүн/

И.ТАМИР /Тооллогын комиссын гишүүн/

Ө.ЭНХЗАЯА /Тооллогын комиссын гишүүн/

**“ИНВЕСКОР ББСБ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР**

2022 он 09 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар:

Улаанбаатар хот

Санал хураалтын дүнгийн тухай

“Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07-р сарын 20-ны өдрийн №24 тоот тогтоол, Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8, 72-р зүйлийг тус тус үндэслэн Компанийн 2022 оны 09-р сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцож, санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг тоолж, дүнг нэгтгэсний үндсэн дээр **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. “Инвескор ББСБ” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулга төслийг батлах тухай асуудлаар:

Хурлын ирц - Нийт 71,419,448 (далан нэгэн сая дөрвөн зуун арван есөн мянга дөрвөн зуун дөчин найм) ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид буюу саналын эрх бүхий нийт хувьцааны 94.29%.

Зөвшөөрсөн 71,077,739 (далан нэгэн сая далан долоон мянга долоон зуун гучин ес) ширхэг хувьцаа буюу хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн хувьцааны 99.52%, татгалзсан 0 (тэг) ширхэг хувьцаа буюу 0%, түдгэлзсэн 0 (тэг) ширхэг хувьцаа буюу 0%, хүчингүйд тооцсон 1,272 (нэг мянга хоёр зуун далан хоёр) ширхэг хувьцаа буюу 0.0018%, санал өгөөгүй 340,437 (гурван зуун дөчин мянга дөрвөн зуун гучин долоо) ширхэг хувьцаа буюу 0.48% байна.

2. Компанийн хувьцаа хуваах тухай асуудлыг батлах асуудлаар:

Хурлын ирц - Нийт 71,419,448 (далан нэгэн сая дөрвөн зуун арван есөн мянга дөрвөн зуун дөчин найм) ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид буюу саналын эрх бүхий нийт хувьцааны 94.29%.

Зөвшөөрсөн 71,077,779 (далан нэгэн сая далан долоон мянга долоон зуун далан ес) ширхэг хувьцаа буюу хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн хувьцааны 99.52%, татгалзсан 0 (тэг) ширхэг хувьцаа буюу 0%, түдгэлзсэн 40 (дөч) ширхэг хувьцаа буюу 0.0001%, хүчингүйд тооцсон 1,272 (нэг мянга хоёр зуун далан хоёр) ширхэг хувьцаа буюу 0.0018%, санал өгөөгүй 340,357 (гурван зуун дөчин мянга гурван зуун тавин долоо) ширхэг хувьцаа буюу 0.48% байна.

3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудлаар:

Хурлын ирц - Нийт 71,419,448 (далан нэгэн сая дөрвөн зуун арван есөн мянга дөрвөн зуун дөчин найм) ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид буюу саналын эрх бүхий нийт хувьцааны 94.29%.

3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч:

Б.Анхболд - Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн кумулятив саналын тооны 71,199,594 ширхэг буюу 99.69%;

Д. Баясгалан - Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн кумулятив саналын тооны 71,109,330 ширхэг буюу 99.57%;

“ИНВЕСКОР ББСБ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурал
хуралдсан газар: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо,
Зайсангийн Тойруу-1, 40 хаягт

Тооллогын комиссын дарга: Х.Галхүү

Тооллогын комиссын гишүүд: Б.Одхүү
И.Тамир
Ө.Энхзаяа

Саналын хуудас тоолж эхэлсэн цаг, минут: 15 цаг 35 минут

Саналын хуудас тоолж дууссан цаг, минут: 16 цаг 10 минут

Тэмдэглэл

Тооллогын комиссын дарга: Хуралд цахимаар оролцсон хувьцаа эзэмшигчдийн санал тооллогыг гаргаж өгнө үү? гэснээр Тооллогын комиссын гишүүд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн 1-р асуудалд санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг тоолж гаргасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал тооллогыг Тооллогын комиссын даргад хүлээлгэн өгөв.

Тооллогын комиссын дарга: Хувьцаа эзэмшигчдийн урьдчилж өгсөн саналын хуудаснуудыг бүртгэсэн мэдээллийг гаргаж өгнө үү? гэснээр Тооллогын комиссын гишүүд Үнэт цаасны компаниудаас Тооллогын комисст 2022 оны 09-р сарын 06-ны 18 цаг 00 минутын дотор хүлээлгэн өгсөн хувьцаа эзэмшигчдийн урьдчилан өгсөн саналын бүртгэл, тооллогыг Тооллогын комиссын даргад хүлээлгэн өгөв. Тооллогын комиссын дарга урьдчилж өгсөн саналын хуудаснуудын бүртгэлийн мэдээллийг тулган баталгаажуулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал тооллогод оруулахыг зөвшөөрөв.

Тооллогын комиссын дарга Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал тооллогыг шалган нягталж нэгтгэсэн нь дараах байдалтай байна. Үүнд:

1. “Инвескор ББСБ” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулга төслийг батлах тухай асуудлаар:

Хурлын ирц - Нийт 71,419,448 (далан нэгэн сая дөрвөн зуун арван есөн мянга дөрвөн зуун дөчин найм) ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид буюу саналын эрх бүхий нийт хувьцааны 94.29%.


Зөвшөөрсөн 71,077,739 (далан нэгэн сая далан долоон мянга долоон зуун гучин ес) ширхэг хувьцаа буюу хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн хувьцааны 99.52%, татгалзсан 0 (тэг) ширхэг хувьцаа буюу 0%, түдгэлзсэн 0 (тэг) ширхэг хувьцаа буюу 0% байна.


2. Компанийн хувьцаа хуваах тухай асуудлыг батлах асуудлаар:

Хурлын ирц - Нийт 71,419,448 (далан нэгэн сая дөрвөн зуун арван есөн мянга дөрвөн зуун дөчин найм) ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид буюу саналын эрх бүхий нийт хувьцааны 94.29%.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлын санал хураасан санал хураалтын дүн болон дүнгийн талаарх шийдвэрийг хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхээр тогтов.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ТЭМДЭГЛЭЛИЙГ БАТАЛГААЖУУЛСАН:


Х.ГАЛХҮҮ / Тооллогын комиссын дарга /


Б.ОДХҮҮ / Тооллогын комиссын гишүүн /

И.ТАМИР / Тооллогын комиссын гишүүн /

Ө.ЭНХЗАЯА / Тооллогын комиссын гишүүн /